Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Монгол улсын Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 26 өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байна. Тус бодлогын баримт бичиг нь стандартад нийцсэн, Оюуны өмчийн газрын бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2024 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 182,292.9 мянган төгрөгөөр буюу 20.35 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------------------------------------|------------------|------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 59,586.9 | 75,453.4 | 15,866.5 |
| Авлага | 23,030.8 | 23,030.8 | - |
| Урьдчилгаа | 60.0 | 60.0 | - |
| Бараа материал | 176,714.8 | 147,198.8 | (29,515.9) |
| Үндсэн хөрөнгө | 668,703.8 | 500,060.3 | (168,643.4) |
| Нийт хөрөнгө | 928,096.3 | 745,803.3 | (182,293.0) |
| Өр төлбөр | 8,225.3 | 51,187.2 | 42,961.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 919,871.0 | 694,616.1 | (225,254.9) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 928,096.3 | 745,803.3 | (182,293.0) |

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад байна. Үүнд:

- Төрийн сан дахь харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 15,866.5 мянган төгрөгөөр өссөн нь барьцаа дансны үлдэгдлээс голлон нөлөөлсөн;
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 29,515.9 мянган төгрөгөөр буурсан нь 107,971.0 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын дотоод хэрэгцээнд зарцуулснаас шалтгаалсан бөгөөд тайлант онд 78,454.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан;

- Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 42,961.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь “Би Ти Эс” ХХК-аас худалдан авсан тоног төхөөрөмжийн төлбөрийн санхүүжилтийн эрхийг Төрийн сан нээгээгүйгээс шалтгаалан он дамжсан өр төлбөр үүссэн;
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 168,643.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тооцсон 219,020.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурч, худалдан авсан 50,377.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн.
- Үүнээс биет бус хөрөнгийн үлдэгдэлд нийт 227,897.6 мянган төгрөгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашигладаг 4 программ хангамж, ДОӨБ-н серверт ашиглагддаг үйлдлийн систем болон хамгаалалтын 7 программ хангамж бүртгэл;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 225,254.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлын санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,200,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,545,231.8 мянган төгрөг, нийт 3,745,231.8 мянган төгрөгийн тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 368,806.2 мянган төгрөгөөр бууруулж, 3,376,425.6 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайлбал, Үндсэн цалин, нэмэгдэл цалингийн зардлыг 10,858.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,954.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 9,553.4 мянган төгрөг, эд хогшил худалдан авахтай холбоотой зардлыг 88,991.7 мянган төгрөг, томилол, зочдын зардлыг 47,287.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 112,973.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 57,548.4 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 46,442.0 мянган төгрөг, нийт 396,608.7 мянган төгрөгөөр бууруулж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 27,802.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 988,126.8 мянган төгрөгийг улсын төсвөөс 2,388,298.8 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос, нийт 3,376,425.6 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар улсын төсвөөс 861,997.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,334,745.7 мянган төгрөг, нийт 3,196,743.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлснээс 2,539,782.9 мянган төгрөгийг зарцуулж, 656,960.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,539,782.9 мянган төгрөг буюу 75.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын арга хэмжээг 626,168.5 мянган төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээг 164,309.5 мянган төгрөг, ажил

Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 46,164.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|--------------|-------------------------------------------------------|--------------------|--------------------|------------------|-------------|
| 70428 | Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт | 3,376,425.6 | 2,539,782.9 | 836,642.7 | 75.5 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,896,291.9 | 2,270,123.4 | 626,168.5 | 78.4 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшил | 264,958.0 | 218,793.3 | 46,164.7 | 82.6 |
| 82569 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 215,175.7 | 50,866.2 | 164,309.5 | 23.6 |

Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар: Монгол Улсын “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч зарим агентлагийн орон тооны дээд хязгаар”-т тус байгууллагад 54 орон тоог баталж гүйцэтгэлээр 54 албан хаагч ажилласан бөгөөд өмнөх онд батлагдсан 59 орон тоог 9 хувиар бууруулсан байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар: Тус газрын даргын 2023 оны А161 дүгээр тушаалаар албан хаагчдад олгох хоолны нөхөх төлбөрийг ажлын нэг өдөрт 20.0 мянган төгрөг байхаар, 2024 оны А28 дугаар тушаалаар албан хаагчдад олгох унааны нөхөх төлбөрийг 1.0 мянган төгрөг байхаар тогтоосон ба тайлант онд хоол, унааны нөхөх олговорт нийт 230,951.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн: Монгол Улсын Оюуны өмчийн газар, Бутаны Хаант Улсын Үйлдвэрлэл, Худалдаа, Хөдөлмөрийн яамны Хэвлэл мэдээлэл, Бүтээлч үйлдвэрлэл ба Оюуны өмчийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан уулзалтад нийт 27,045.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тус уулзалтын үр дүнд хоёр талын харилцааг улам гүнзгийрүүлж, бүтээлч эдийн засаг, зохиогчийн эрх, соёлыг сурталчлах чиглэлээр тогтвортой хамтын ажиллагааны шинэ боломжуудыг нээж өгсөн, соёлын дипломат харилцааг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан гэж дүгнэсэн байна.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн: Тайлант онд сургалт, семинар, зөвлөгөөнд нийт 36,169.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тус арга хэмжээний үр дүнд Оюуны өмчийн зөрчил, маргаан шийдвэрлэх Олон Улсын сайн жишээг суралцаж, мэргэжилтнүүдтэй санал солилцох, туршлага хуваалцах, хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар ДООБ-ын зөвлөхүүдээс зөвлөгөө авч ажилласан байна. Оюуны өмчийн эрх эзэмшигч, Монгол Улсын ЖДҮ эрхлэгчдийн төлөөллүүдэд өөрсдийн үйлдвэрлэл, үйлчилгээг хэрхэн Олон Улсын зах зээлд гаргах, оюуны өмчтэй холбоотой шийдвэрийг өөрсдийн бизнесийн боломж, стратегийн зорилгод уялдуулан хэрхэн эрэмбэлэх талаар зөвлөмж хүргүүлсэн нь чухал ач холбогдолтой, үнэ цэнтэй мэдээлэл олж авсан үйл явдал болсон гэж үзлээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 12,657.9 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос бүрдүүлж, 12,657.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Оюуны өмчийн газар нь тайлант онд нийт 100,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан нээлттэй тендер шалгаруулалтаар 45,983.0 мянган төгрөгийн программ хангамж, 54,017.0 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авахаар төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтад байршуулсан байна.

Гүйцэтгэлээр үнэлгээний хороо байгуулан 100,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багцад тендер зарлаж, 100,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулах эрх олгосноор 37,294.5 мянган төгрөгийг лиценз, 88,481.7 мянган төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Оюуны өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төгсгүүд консалтинг аудит ХХК-ийн аудитор А.Саранцэцэг, аудиторын туслах Ч.Мандахтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Сарантуяа, компанийн захирал, аудитор Р.Даваа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага ба цэвэр зээлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага ба цэвэр зээлийн 2,764,487.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,644.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлант онд 6,891.8 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох, давтан гаргахгүй 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБ-ын ОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 171 мэдээлэл байршуулахаас 170 мэдээлэл байршуулж, 1 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна. Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 5,257,422.4 мянган төгрөгийн 23 гүйлгээ, зарлагын 3,645,339.1 мянган төгрөгийн 53 гүйлгээг иж бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитад хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгийн данснуудад горим сорил хэрэгжүүлсэн. Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулан аудитаар илрүүлсэн 144,534.2 мянган төгрөгийн алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 195,909.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагын нийт биелэлт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар өгсөн | | Биелэлт | | |
|--------------------------------------|----------------------|------------------|----------|------------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 4 | 195,909.0 | 4 | 195,909.0 | 100.0 |
| Хариуцлага тооцуулах албан шаардлага | 1 | - | 1 | - | 100.0 |
| Нийт дүн | 5 | 195,909.0 | 5 | 195,909.0 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

- Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
- Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 7,189.8 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа: УСНББОУС 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт ба алдаа стандартын 46-д "... тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг..." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д " аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа нарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу дараах алдааг бүрэн залруулсан. Үүнд.

- Бараа материалын шинжтэй 7,189.8 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж тайлагнасныг бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн.

Аудитаар илрүүлэн нийт 17,710.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн 17,710.0 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,934.9 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 08 сарын 22-ны өдрийн А/123 тоот тушаалаар баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг өөр албан тушаалтнуудад хавсран гүйцэтгүүлж, хүний эрхийн болон жендерийн эрх тэгш байдлын тайлан, мэдээг гаргуулахаар үндсэн цалинг 10 хувиар нэмж, нийт 3,371.8 мянган төгрөгийн цалин хөлс олгосон;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 9 дүгээр сарын 01/2429 тоот албан бичгээр 2025 оны 9 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд сайдын нэрэмжит спортын зургаан төрөлт тэмцээн зохион байгуулагдаж, тус тэмцээнд оролцох багийн тамирчдад төсвөөс 3,520.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 08 сарын 22-ны өдрийн А/123 тоот тушаалаар баталсан ажлын байрны тодорхойлолт: Зохиогчийн эрхийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтын 3 дугаар зорилтын 7-д "Жендерийн эрх тэгш байдлын хангах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах", Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын 2 дугаар зорилтын 1-д "Төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг нэгжүүдээс хүлээн авч нэгтгэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэнд хүлээлгэх өгөх", мөн төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн

байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөс биеийн тамирын хувцас худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг давхардуулж хүний эрхийн болон жендерийн эрх тэгш байдлын тайлан, мэдээг гаргуулахаар хавсран ажиллуулахдаа гаргасан тушаалыг хүчингүй болгож, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 8-ны А/61 тоот тушаалаар Америкийн нэгдсэн улсын Калифорния Мужийн Сан Диего хотод зохион байгуулагдсан "Олон улсын барааны тэмдгийн холбоо"-ны 147 дахь удаагийн уулзалтад оролцох тухай шийдвэрийн дагуу байгууллагын захирлын 2025 оны А/50 тоот тушаалаар 5 албан тушаалтныг тус уулзалтад оролцуулснаас зайлшгүй шаардлагатай бус 2 албан тушаалтан /улсын байцаагч, мэргэжилтэн/ оролцож нийт 10,818.2 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт төсвөөр санхүүжигдсэн гадаад томилолтод алба хаагчдыг оновчтой сонгож оролцуулаагүй, нэмэлт төсвийг үргүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------|------------|----------------|-----------------------------------|-----|--------------------------|----------------|------------|----------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Бараа материалын шинжтэй 7,189.8 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж тайлагнасан байна. | 1 | 7,189.8 | | | 1 | 7,189.8 | 1 | 7,189.8 | | | | |
| Дүн | 1 | 7,189.8 | | | 1 | 7,189.8 | 1 | 7,189.8 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан дараах зөрчлүүд байна. Үүнд: -Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 08 сарын 22-ны өдрийн А/123 тоот тушаалаар баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг өөр албан тушаалтнуудад хавсран гүйцэтгүүлж, хүний эрхийн болон жөндөрийн эрх тэгш байдлын тайлан, мэдээг гаргуулахаар үндсэн цалинг 10 хувиар нэмж, нийт 3,371.8 мянган төгрөгийн цалин хөлс олгосон; -Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 9 дүгээр сарын 01/2429 тоот албан бичгээр 2025 оны 9 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд сайдын нэрэмжит спортын зургаан төрөлт тэмцээн зохион байгуулагдаж, тус тэмцээнд оролцох багийн | 1 | 6,891.80 | | | 1 | 6,891.80 | | |

Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | | | |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|------------------|--|--|----------|------------------|--|--|
| тамирчдад төсвөөс 3,520.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авсан байна. | | | | | | | | |
| Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 8-ны А/61 тоот тушаалаар Америкийн нэгдсэн улсын Калифорни Мужийн Сан Диего хотод зохион байгуулагдсан “Олон улсын барааны тэмдгийн холбоо”-ны 147 дахь удаагийн уулзалтад оролцох тухай шийдвэрийн дагуу байгууллагын даргын 2025 оны А/50 тоот тушаалаар 5 албан тушаалтныг тус уулзалтад оролцуулснаас зайлшгүй шаардлагатай бус 2 албан тушаалтан /улсын байцаагч, мэргэжилтэн/ оролцож нийт 10,818.2 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан байна. | 1 | 10,818.20 | | | 1 | 10,818.20 | | |
| Дүн | 2 | 17,710.00 | | | 2 | 17,710.00 | | |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 361/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/188/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 8-ны А/61 тоот тушаалаар Америкийн Нэгдсэн Улсын Калифорни Мужийн Сан Диего хотод зохион байгуулагдсан “Олон улсын барааны тэмдгийн холбоо”-ны 147 дахь удаагийн уулзалтад оролцох тухай шийдвэрийн дагуу байгууллагын захирлын 2025 оны А/50 тоот тушаалаар 5 албан тушаалтныг тус уулзалтад оролцуулснаас зайлшгүй шаардлагатай бус 2 албан тушаалтан /улсын байцаагч, мэргэжилтэн/ оролцож 10,818,200.00 /арван сая найман зуун арван найман мянга хоёр зуун/ төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэлт төсвөөр санхүүжигдсэн гадаад томилолтод алба хаагчдыг оновчтой сонгож оролцуулаагүй, нэмэлт төсвийг үргүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан, нягтлан бодогч Д.Отгонсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТӨГСГҮҮД КОНСАЛТИНГ
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Р.ДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-61.Docx

1526180762



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 362/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/188/НА -СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Оюуны өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/123 тоот тушаалаар баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг өөр албан тушаалтнуудад хавсран, гүйцэтгүүлж, хүний эрхийн болон жендерийн эрх тэгш байдлын тайлан, мэдээг гаргуулахаар үндсэн цалинг 10 хувиар нэмж, нийт 3,371,800.00 /гурван сая гурван зуун далан нэгэн мянга найман зуун/ төгрөгийн цалин хөлс олгосон;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 02/2429 тоот албан бичгээр 2025 оны 9 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд сайдын нэрэмжит спортын зургаан төрөлт тэмцээн зохион байгуулагдаж, тус тэмцээнд оролцох багийн тамирчдад төсвөөс 3,520,000.00 /гурван сая таван зуун хорин мянган/ төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/123 тоот тушаалаар баталсан ажлын байрны тодорхойлолт: Зохиогчийн эрхийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтын 3 дугаар зорилтын 7-д "Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах", Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын 2 дугаар зорилтын 1-т "Төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг нэгжүүдээс хүлээн авч нэгтгэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэнд хүлээлгэх өгөх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-61.Docx

1526180760

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгөөс биеийн тамирын хувцас худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг давхардуулж хүний эрхийн болон жендерийн эрх тэгш байдлын тайлан, мэдээг гаргуулахаар хавсран ажиллуулахдаа гаргасан тушаалыг хүчингүй болгож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга /Г.Элбэгсайхан/, нягтлан бодогч /Д.Отгонсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТӨГСГҮҮД КОНСАЛТИНГ
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Р.ДАВАА

Зөрчил таслан зогсоох тухай